

ОЛОН ТАЛТ ЗӨВЛӨЛ



ТАЛУУДЫН ОРОЛЦОО

Талуудын оролцоо гэдэг нь байгалийн нөөц ашиглалтад оролцогч талуудын тогтвортой хөгжилд чиглэсэн, хамтын ажиллагааны, урт хугацааны үргэлжилсэн үйл явц юм.

Хамтын ажиллагаа гэж талууд зөвхөн мэдээллээ солилцоод өнгөрөх бус “хамтрагч”, “түншлэгч” гэсэн байр суурин дээр ажиллана. Өөрөөр хэлбэл, эрх мэдэл, нөөцийг үр ашигтай ашиглах хэмжээнд талууд бие биенээ хүлээн зөвшөөрөхийг хэлнэ.

Урт хугацааны үргэлжилсэн үйл явц нь байгалийн нөөцийн хайгуулын үеэс эхлэн ашиглаж дуусах хүртэлх хугацаанд оролцоо тасралтгүй явагдаж байхыг хэлдэг.




ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ГЭДЭГ НЬ хязгаарлагдмал нөөц бүхий энэ дэлхий дээр хүн төрөлхтөний амьдралыг зөв зохион байгуулах зарчим юм.

“Эх дэлхийгээ бид өвөг дээдсээсээ өвлөж авсан бус, харин үр хүүхэд, хойч үеэсээ зээлж буй хэрэг.”
Сиетлийн удирдагчийн захидал. 1852 он.

Монголын өнөө болон хойч үеийнхний сайн сайхан амьдрах баталгаа-амьдралыг тэтгэх тогтолцоог найдвартай хамгаалж, тогтвортой хөгжихийг **НОГООН ХӨГЖИЛ** гэнэ.



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, ТҮҮНД ХҮРЭХ АЛСЫН ХАРАА

“Үндэсний байгаль, соёл, түүхийн өв, уламжлалыг орчин үеийн хөгжлийн ололт, амжилттай хослуулан баяжуулсан, Монгол хүнээ эрхэмлэн дээдэлсэн “сайн” засаглалтай, байгаль орчинд ээлтэй технологи ба мэдлэгт суурилсан эдийн засагтай, уур амьсгалын өөрчлөлтөд ухаалгаар дасан зохицсон, байгаль, эх дэлхийгээ хайрлан хамгаалах үндэсний ухамсар төлөвшсөн ногоон соёл иргэншлийн үндсийг бий болгосон хөгжингүй улс болно”. Монгол Улсын Ногоон Хөгжлийн үзэл баримтлалаас.



НОГООН УЛ МӨР

“Байгалийн баялаг, хүрээлэх орчны хүрээнд хүний явуулж буй үйл ажиллагааны болон аливаа үйлдвэрлэлээс гарч буй нийтлэг бүх нөлөөллийг тооцох үзүүлэлт”
“Хүн бүрийн өдөр тутам ашиглаж, хэрэглэж буй нөөцийг хэмжих ойлголт.



УУЛ
УУРХАЙН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



The Asia Foundation

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

=



ХҮЛЭМЖИЙН ХИЙН
ЯЛГАРАЛ БАГАТАЙ



БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХЭМНЭЛТТЭЙ
АШИГЛАЛТЫГ ДЭМЖСЭН



НИЙГМИЙН САЙН САЙХАН,
ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА

=

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

“НОГООН ХӨГЖИЛ” гэж байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашигласан, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, нийгмийн оролцоог хангаж ядуурлыг бууруулах хөгжлийн загварыг хэлнэ.

“НОГООН САНХҮҮЖИЛТ” гэж байгалийн нөөц баялаг, экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг хадгалж, эрчим хүч, түүхий эд материал, усны хэрэглээг багасгах технологи ашиглах төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх, тэдгээрт хөрөнгө оруулахыг хэлнэ.

“НОГООН ХОТ” гэж эрчим хүч, дулаан, ус хангамж, харилцаа холбоо, нийтийн тээврийн ухаалаг дэд бүтэц, хог хаягдлын оновчтой менежмент бүхий хүний амьдралын тав тух, хөгжлийн боломжийг хангасан хот сууринг хэлнэ.

“НОГООН ӨСӨЛТ” гэж хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалах, нийгмийн оролцоог дэмжих, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн өсөлтийг хэлнэ.

“НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛ” гэж эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэлнэ.

“НОГООН АЖИЛ” гэж эрчим хүч, түүхий эд материал, усны хэрэглээг багасгах, хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлах, хог хаягдал, бохирдлыг бууруулах, экосистемийг хамгаалж нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох замаар хүрээлэн байгаа орчны чанарыг сайжруулж, хамгаалахад чиглэсэн ажил хөдөлмөрийг хэлнэ.

“ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР” гэж экосистемийн үйлчилгээг хүртэгч болон уг үйлчилгээг тогтвортой хадгалахад хувь нэмрээ оруулагчийн хооронд бий болгох төлбөрийн зохицуулалтын механизмыг хэлнэ.

“ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” гэж байгалиас заяасан хүнс, түүхий эд, байгалийн нөөцөөр хангах, уур амьсгал, орчны эрс өөрчлөлтийн нөлөөг зохицуулах, хүний амьдралыг тэтгэх, оюуныг сэргээх үр өгөөжийг хэлнэ.

“НОГООН БАРИЛГА” гэж хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материал ашигласан, дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, агаарт ялгаруулах хаягдал багатай халаалтын шийдэлтэй, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлт үр ашигтай, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлсэн барилга байгууламжийг хэлнэ.

“НОГООН ТАТВАР” гэж байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний импорт, хэрэглээг багасгахад чиглэсэн татварыг хэлнэ.

“НОГООН ЭДИЙН ЗАСАГ” гэж байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг хэлнэ.



УУЛ
УУРХАЙН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



The Asia Foundation

ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ЭРҮҮЛ ЭКОСИСТЕМ ХҮНИЙ САЙН САЙХАН АМЬДРАЛЫН ЭХ СУРВАЛЖ



**ЭКОСИСТЕМИЙН
ҮҮРЭГ БОЛОН
БАЙГАЛИЙН ҮЙЛ ЯВЦ**
(Анхдагч
бүтээгдэхүүн)



**ЭКОСИСТЕМИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ**
(Ус, агаар, мод, хөдөө аж
ахуйн бүтээгдэхүүн, барилгын
бүтээгдэхүүн гэх мэт)



**БАРАА
БҮТЭЭГДЭХҮҮН**
(Хоол хүнс,
хангамж гэх мэт)



**ХҮМҮҮСИЙН САЙН
САЙХАН БАЙДАЛ**
(Эдийн засаг, эрүүл
мэнд, нийгмийн
халамж)

ЭКОСИСТЕМ ГЭДЭГ БОЛ бие биетэйгээ харилцан тогтолцоонд оршдог ургамал, амьтан зэрэг биофизикийн элементүүд болон агаар, ус зэрэг физикийн элементүүдийн цогц харилцаа юм. Эдгээр цогц үйл ажиллагаанууд нь хүмүүст ашиг тус өгдөг экосистемийн үйлчилгээ болох олон төрлийн үйлчилгээг бий болгодог.

ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДӨРВӨН ТӨРӨЛ

- ✦ **Хангамжийн үйлчилгээнүүд:** хүмүүсийн экосистемээс олж авч буй бүтээгдэхүүнүүд (жишээ нь, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, ундны ус, барилгын материал, г.м.);
- ✦ **Зохицуулалтын үйлчилгээнүүд:** хүмүүсийн экосистемийн үйл ажиллагааны зохицуулалтаас авч буй ашиг (жишээ нь, ус ба агаар цэвэршүүлэлт, хөдөө аж ахуйн хортон шавж ба өвчинтэй тэмцэх, байгалийн гамшигийн үр дагаврыг бууруулах, г.м.);
- ✦ **Соёлын үйлчилгээнүүд:** хүмүүсийн экосистемээс авч буй материаллаг бус ашиг (жишээ нь, зугаа цэнгэл, идэвхитэй амралт болон гоо зүйн таашаал авах зорилгоор аялдаг газрууд);
- ✦ **Дэмжих үйлчилгээнүүд:** бусад үйлчилгээнүүдийг дэмждэг ердийн үйл ажиллагаа (жишээ нь, тэжээллэг бодис авах, дахин боловсруулалт, анхдагч үйлдвэрлэл явуулах, генетикийн солилцоо хийгдэх арга зам).



УУЛ
УУРХАЙН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



The Asia Foundation

БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМУУД

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөг үнэлэх, нөлөөллөөс зайлсхийх, нөлөөг бууруулах, арилгах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, байгаль орчныг хамгаалах нэмэлт ажлууд зохион байгуулах цогц үйл ажиллагаа нь биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах үндсэн арга зам юм.


Энэ нь цаашид үүсэж болох эрсдэл,

үл ойлголцлоос сэргийлэн, хуримтлагдах нөлөөлөл болон нийгмийн хариуцлагыг бүрэн хэрэгжүүлэх зорилготой холбоотой.

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй биологийн төрөл зүйлийн сөрөг нөлөөллийг бууруулахад “Сөрөг нөлөөлөл бууруулах шатлалын тогтолцоог” баримтална.



СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ ШАТЛАЛЫН ТОГТОЛЦОО



ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ ГЭЖ ЮУ ВЭ?

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ гэдэг нь бүх оролцогч талуудын, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурлаж, хууль сахиx ёсыг дээдэлсэн, Монгол Улсад байнгын ашиг орлого оруулж байх эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг хэлнэ.

“Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачлага” ТББ



**ХАРИУЦЛАГАТАЙ БИЧИЛ
УУРХАЙ** гэдэг нь орон нутгийн
эдийн засаг, амьжиргаанд хувь
нэмэр оруулахуйц, хуулийн
дагуу зохион байгуулагдсан
бичил уурхайчдад аюулгүй,
байгаль орчинд хал багатай
үйл ажиллагаа юм.

*“Монголын бичил уурхайн
нэгдсэн дээвэр” холбоо*



УУЛ
УУРХАЙН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



The Asia Foundation